

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	2
2.Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.Менежментийн захидал	9
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	16
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

2020. 04.24 № 1444
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

A red square stamp containing a handwritten signature in black ink. The signature is written in a cursive style. The stamp also contains Mongolian text in red, which is partially obscured by the signature. The text appears to be "Төрийн аудитын байгууллага" (State Audit Agency) and "Замуурч" (Auditor).

Д.ЗАНДАНБАТ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн он удаан жил болсон авлага болон татварын өглөгийг барагдуулах, санхүүгийн программын хөгжүүлэлтийг хийлгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 05-аас 4 дүгээр сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Долгоржав хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 14/385 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Их Хурлын алсын хараа: Монгол Улсын Үндсэн хууль, ардчилсан ёс, хүний эрх, нийтлэг үнэт зүйлс, үндэснийхээ эрх ашгийг дээдэлж, тогтвортой хөгжлийг дэмжин, ард түмний засаглах эрхийг хангасан парламентыг төлөвшүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын эрхэм зорилго нь ард түмний төлөөллийг хангаж, засаглах эрхийг хангасан парламент байхад оршино.

Дээрх эрхэм зорилгыг хангаж ажиллахын тулд дараах стратегийн зорилгыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд

1. Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааг төгөлдөржүүлж, түүний чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.
2. Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж, хуулийн хэрэгжилт, түүний үр нөлөөг үнэлэх байнгын тогтолцоог бүрдүүлж, чадавхжуулна.
3. Улсын Их Хурал төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, парламентад итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлнэ.
4. Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлж, парламент хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
5. Улсын Их Хурлын чадавхыг бэхжүүлж, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ.
6. Парламентын ажлын мэргэшсэн алба-Улсын Их Хурлын Тамгын газрын чадавхыг дээшлүүлж, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгон, олон улсын жишигт хүргэнэ.

Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн ерөнхийлөн захирагчийн өдөр тутмын үйл ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчилсөн
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Жишиг норм”
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллага санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн “Unicus” программ хангамж ашиглан санхүүгийн тайланг бэлтгэсэн боловч хөрөнгийн бүртгэлийг дутуу боловсруулан тайлагнаж байна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж түүнд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэл бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 20,082.5 сая төгрөгийн 2 хувиар тооцож 401.6 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшнийг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 40,935.7 сая төгрөгийг суурь үзүүлэлт болгон сонгон 2 хувиар тооцож материаллаг байдлын түвшинг 818.7 сая төгрөгөөр тогтоолоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 91.1 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материал, өр төлбөр данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	0.6	0.0	(0.6)
Авлага	7.9	7.7	(0.2)
Бараа материал	492.0	443.9	(48.1)
Үндсэн хөрөнгө	6,810.9	6,768.7	(42.2)
Нийт хөрөнгө	7,311.4	7,220.3	(91.1)
Өр төлбөр	12.3	4.1	(8.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,299.1	7,216.2	(82.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,311.4	7,220.3	(91.1)

Төсвийн ерөнхий захирагчид хамаарч байсан “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл Сангийн сайдын багцад нэгтгэх болсноор мөнгөн хөрөнгө 0.6 сая, авлага 1.0 сая, бараа материал 6.6 сая, үндсэн хөрөнгө 106.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Авлагын эцсийн үлдэгдэлд “Монгол шуудан” ХХК-с 2.7 сая, “Билгүүн засаг” ХХК-с авах 5.0 сая төгрөгийн авлага байна.

Тайлант хугацаанд 1,429.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 1,471.4 сая төгрөгийн материал зарцуулан 443.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу өмнөх оноос 48.1 сая төгрөгөөр буурсан байна. 2019 онд бичиг хэрэг 3.7 сая, аж ахуйн материал 18.3 сая, бусад хангамжийн материал 19.6 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Нийт бараа материалд бичиг хэрэг 72.1 сая төгрөг буюу 16.2 хувь, аж ахуйн материал 13.9 сая төгрөг буюу 3.1 хувь, серверийн сэлбэг хэрэгсэл 143.4 сая төгрөг буюу 32.3 хувь, бусад хангамжийн материал 214.5 сая төгрөг буюу 48.4 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 120.1 сая, хөрөнгө оруулалтаар бий болсон 1,692.8 сая нийт 1,812.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тооцоолсон элэгдлийн зардал 1,749.1 сая төгрөгөөр буурсан байна.

“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн 10.3 төгрөгийн өглөг Сангийн сайдын багцад шилжснээс өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 8.2 сая төгрөгөөр буурсан боловч тайлант онд ажиллагсдаас суутган тооцсон хувь хүний орлогын албан татварын 2.1 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 40,356.4 сая төгрөгийг баталснаас 40,256.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 100.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Улсын төсвөөс 39,949.3 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, батлагдсан төсвөөс 307.1 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Туслах үйл ажиллагаанаас 132.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 96.2 сая төгрөгийн орлого үндсэн үйл ажиллагааны дансанд, 36.4 сая төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрчээ.

Урсгал зардлаас нийт 1,134.2 сая төгрөг дутуу зарцуулсан байна. Тухайлбал: УИХ -ын зарим гишүүд Засгийн газрын гишүүний ажлыг давхар гүйцэтгэснээс 233.4 сая төгрөгийн цалингийн зардал, УИХ үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлт хэлэлцэхтэй холбогдуулан завсарлагагүй ажиллаж зарим гадаад томилолтын төлөвлөгөөт ажлууд хэрэгжээгүйгээс 126.4 сая төгрөгийн томилолтын зардал, УИХ гишүүдийн зардлыг хэмнэх горим баримтлан ажилласнаас 327.5 сая төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардал дутуу зарцуулагдсан байна.

Хөрөнгийн зардалд хөрөнгө оруулалтын 21 төсөл, арга хэмжээнд 2,000.0 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 1,693.2 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, худалдан авалтын хэмнэлтээс 16.8 сая, чуулган завсарлагагүй хуралдсанаас засварын ажил хийгдээгүй 290.0 сая нийт 307 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 39,222.3 сая төгрөг буюу 97.2 хувьтай ба зарцуулагдаагүй үлдэгдэл 823.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: “Үндсэн хууль”-ийн нэмэлт өөрчлөлтийн ажлын хэсгийн зардалд Засгийн газрын нөөц сангаас 852.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, 844.5 сая төгрөгийг зарцуулснаас үлдсэн 7.9 сая, үйл ажиллагааны орлого нэмэлт төсвийн дансанд төвлөрүүлсэн 36.4 сая төгрөг буюу нийт 44.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон 9 эрсдэлийн дагуу гүйцэтгэх үе шатанд горим сорил хэрэгжүүлэхэд 5.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн бөгөөд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өгснийг менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх чухал асуудал байхгүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын шилэн данс цахим хуудсанд тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 124 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 442.9 сая төгрөгийн зөрчилд өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Улсын Их Хурлын даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС, АОУС, журам, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Аудитаар 5.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон 818.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим чиглэгдсэн.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан асуудлууд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлага данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

“Билгүүн засаг” ХХК-иас 2015 онд үүссэн 5.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалт, УСНББОУС-28-ын заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Олон жил болсон авлага найдваргүй болох;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллахаар болов.

3.2 Санхүүгийн программ хангамжтай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн Unicus программыг 2014 оноос сайжруулалт хийгээгүйгээс хөрөнгийн бүртгэл дутуу боловсруулагдаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ын 1.3 “журнал, ерөнхий данс, санхүүгийн тайланд тодруулга хийх боломжтой болон бүртгэлийн маягтууд нь стандартын шаардлагыг хангасан байх”, 3 “Нягтлан бодох бүртгэлийн программд дараах модулийг иж бүрэн хамруулсан байна”, 3.7 “үндсэн хөрөнгө /ашиглалт, дахин үнэлгээ, элэгдлийн

арга/-ийн бүртгэл”, 3.10 “биет бус хөрөнгийн бүртгэл /элэгдэл, хорогдол тооцолт/” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сул байх;

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн бүртгэлийг санхүүгийн программд бүрэн боловсруулдаг болгох хөрөнгийн бүртгэл, ашиглалтад хяналт тавих;

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Программыг Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалын дагуу шийдвэрлэхээр болов.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(мянган төгрөгөөр)

Код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	500,538.2	451,599.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	597.0	0.0
33	АВЛАГА	7,902.2	7,750.7
35	БАРАА МАТЕРИАЛ	492,039.0	443,849.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,810,934.7	6,768,714.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,810,934.7	6,768,714.4
392	Биет хөрөнгө	6,672,710.8	6,518,337.2
393	Биет бус хөрөнгө	138,223.9	250,377.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,311,472.9	7,220,314.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,319.3	4,150.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,319.3	4,150.8
413	Өглөг	12,319.3	4,150.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,299,153.6	7,216,163.5
51	Засгийн газрын хувь оролцоо	7,299,153.6	7,216,163.5
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,560,849.8	3,560,849.8
512	Хуримтлагдсан үр дүн	3,738,303.8	3,655,313.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,311,472.9	7,220,314.3

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	33,088,176.3	40,956,554.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,765,434.8	154,894.5
120	Нийтлэг татварын бус орлого	99,923.9	154,894.5
122	Тусламжийн орлого	2,665,510.9	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,322,741.5	40,801,660.4
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	32,402,112.9	40,935,686.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,402,112.9	40,935,686.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,227,003.0	39,697,654.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,230,598.7	9,833,580.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	976,816.4	1,188,207.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,321,003.3	1,161,040.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,553.9	61,850.0
2107	Томилолт, зочны зардал	1,694,017.8	2,837,386.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,945,869.9	1,084,146.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,010,143.0	23,531,443.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,175,109.9	2,238,032.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	686,063.5	20,868.8
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	26.0	0.0
5	НИЙТ ҮР ДҮН	686,037.5	20,868.8

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	32,504,788.1	40,934,269.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,178,255.7	96,184.1
120	Нийтлэг татварын бус орлого	0.0	96,184.1
122	Тусламжийн орлого	2,178,255.7	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,326,532.4	40,838,085.1
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,708,300.0	39,121,964.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,708,300.0	39,121,964.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,533,190.1	37,883,335.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,242,844.4	9,833,580.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	959,954.1	1,188,207.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,217,197.7	1,221,582.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,406.6	4,996.5
2107	Томилолт, зочны зардал	1,694,017.8	2,837,386.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,946,452.8	1,015,288.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,468,316.7	21,782,294.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,175,109.9	1,238,629.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,796,488.1	1,812,304.6
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,797,448.3	1,812,901.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,797,448.3	1,812,901.7
2200	Дотоод эх үүсвэрээр	1,797,448.3	1,812,901.7
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,797,448.3	-1,812,901.7
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-960.2	-597.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,557.2	597.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	597.0	0.0

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр/өмч
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,613,116.1		6,613,116.1
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0		0.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,613,116.1		6,613,116.1
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.0		0.0
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.0		0.0
C07	Тайлант үеийн үр дүн	686,037.5		686,037.5
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,299,153.6		7,299,153.6
D01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	7,299,153.6		7,299,153.6
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-103,858.9		-103,858.9
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,195,294.7		7,195,294.7
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.0		0.0
D08	Тайлант үеийн үр дүн	20,868.8		20,868.8
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,216,163.5		7,216,163.5

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,356,451.4	39,222,252.4	1,134,199.0	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,356,451.4	37,529,443.4	827,008.0	97.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,961,474.4	37,158,948.9	802,525.5	97.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,067,028.7	9,833,580.0	233,448.7	97.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,227,128.7	1,188,207.4	38,921.3	96.8
2104	Хангамж, бараа материалын зардал	1,281,540.0	1,221,582.2	59,957.8	95.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	125,150.0	125,089.1	60.9	100.0
2107	Томилот, зочны зардал	2,963,757.8	2,837,386.3	126,371.5	95.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,031,580.0	1,015,288.4	16,291.6	98.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,265,289.2	20,937,815.5	327,473.7	98.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	394,977.0	370,494.5	24,482.5	93.8
	Засгийн газрын урсгал шилжүүлэг	43,053.1	36,221.6	6,831.5	84.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	351,923.9	334,272.9	17,651.0	95.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,000,000.0	1,692,809.0	307,191.0	84.6
2200	Дотоод эх үүсвэрээр	2,000,000.0	1,692,809.0	307,191.0	84.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,356,451.4	40,045,444.5	311,006.9	99.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,256,451.4	39,949,260.4	307,191.0	99.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	100,000.0	96,184.1	3,815.9	96.2
	Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын зөрүү		-823,789.1		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		597.0		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	622	622		
620001	Удирдах ажилтан	103	103		
620002	Гүйцэтгэх ажилтан	487	487		
620003	Үйлчлэх ажилтан	32	32		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	622	622		
	Төрийн өндөр албан тушаалтан	82	82		
	Улс төрийн албан хаагч	358	358		
650001	Төрийн захиргааны албан хаагч	150	150		
650009	Төрийн үйлчилгээний албан хаагч	32	32		

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		888,824.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ		888,824.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		888,824.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		844,400.0
	Төвлөрүүлэг		44,424.7
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		888,824.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		852,400.0
1200	Бусад орлого		36,424.7
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.0

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2020/29/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Улсын Их Хурлын дарга			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	2015 онд үүссэн 6.9 сая төгрөгийн авлага барагдуулаагүй байна.	5.0	Зөвлөмж өгөх	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Санхүү, хангамж үйлчилгээний даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Л.Өлзийсайхан
2	Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн Unicus программыг 2014 оноос сайжруулалт хийлгээгүйгээс хөрөнгийн бүртгэл дутуу боловсруулагдаж байна.	-	Зөвлөмж өгөх		
	Дүн	5.0			

